



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 17 өдөр

Дугаар A/50

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Арьс шир, цүнх, гутлын холбоогоор дамжуулан арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрүүдтэй холбоо тогтоох, уулзалт зохион байгуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллах, түнш олох зорилгоор ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч
Ахлах мэргэжилтэн

П.Түвшинзаяа

Ажлын хэсгийн гишүүд
Хөрөнгө оруулалтын төлөвлөлт
хариуцсан эдийн засагч
Дотоод хяналт-шинжилгээ,
үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

М.Жавхланчимэг

А.Нямхүү

2. Холбоо харилцаа тогтоох, томилолтыг удирдамж боловсруулж, үр дүнг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдөр танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /П.Түвшинзаяа/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн Ерөнхий инженер бөгөөд барилгын инженер /Г.Пүрэвдорж/-д даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ

3150600050